



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Ховд аймгийн Цэцэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/164/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Аудитор: Д.Нарантуул
Утас: 99019800
цахим хаяг: narantuul.d@audit.gov.mn
Эл би альфа аудит экспэйншин Аудит ХХК
Аудитор: Н.Дэмбэрэлдорж

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.5.1 Төсвийн төлөвлөлт	12
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ...	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	Error! Bookmark not defined.
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн Тайлангийн Аудит



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ЦЭЦЭГ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.МӨНХТӨР ТАНАА

2023.03.22 № 02/108
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Цэцэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Цэцэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй, тайлант онд авлага их хэмжээгээр нэмэгдүүлсэн, шатахуун, томилолтын зардлын зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүй 43.2 сая төгрөгийн зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, АДБОУС 1250, иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант хугацаанд Боловсрол шинжлэх ухааны газраас 4.6 сая төгрөгийн түрээсийн сурах бичиг, төсвийн хөрөнгөөр 45.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсноор аудитын гол асуудал гэдэг нь аудиторов мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудалгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Тус сургууль нь 560 хүүхэд хүлээн авах хүчин чадалтайгаас 2022 онд 24 бүлэгт 681 хүүхэдтэйгээр 33 багштай, 58 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. 2022 онд 3

021020332

Тус сургууль нь 2022 онд 1-5 дугаар ангийн 11 бүлэгт нийт 44835 хүүхэд өдөр үдийн хоол арга хэмжээг хэрэгжүүлж 67.2 сая төгрөгийг зарцуулжээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	90,011,144.39	125,530,111.01
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	27,820,457.42
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	27,820,457.42
3121	Төгрөг	00.00	27,820,457.42
31211	Төрийн сангийн харилцах	00.00	27,820,457.42
33	АВЛАГА	12,163,605.31	23,752,918.49
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,685,755.31	20,527,918.49
335	Бусад авлага	8,477,850.00	3,225,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	8,477,850.00	3,225,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	77,847,539.08	73,956,735.10
351	Түүхий эд материал	5,959,805.00	4,591,085.00
35110	Тусгай зориулалттай материал	3,926,085.00	3,926,085.00
35130	Эм боох материал	2,033,720.00	665,000.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	5,172,000.00	11,312,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	24,016,793.08	8,700,000.00
354	Хангамжийн материал	18,683,941.00	26,249,650.10
35420	Аж ахуйн материал	294,000.00	4,631,800.00
35460	Хүнсний материал	4,416,800.00	7,201,300.00
35470	Бусад хангамжийн материал	13,632,141.00	14,416,550.10
35600	Мал амьтад	24,015,000.00	23,104,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,698,713,005.06	1,615,047,534.16
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,698,713,005.06	1,615,047,534.16
392	Биет хөрөнгө	1,651,065,005.06	1,567,399,534.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,834,811,784.00	1,834,811,784.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-306,683,604.50	-411,632,951.60
39203	Авто-тээврийн хэрэгсэл	29,736,434.00	29,736,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-29,736,434.00	-29,736,434.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	186,594,769.20	232,220,889.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-139,126,555.50	-160,135,249.60
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	120,196,497.00	120,196,497.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-79,987,963.70	-87,120,613.40
39214	Бусад үндсэн хөрөнгө	100,000.00	100,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-100,000.00	-100,000.00
39217	Ном	35,260,078.56	39,059,178.56
393	Биет бус хөрөнгө	47,648,000.00	47,648,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	47,648,000.00	47,648,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,788,724,149.45	1,740,577,645.17
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,152,602.87	416,114.11
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,152,602.87	416,114.11
413	Өглөг	3,152,602.87	416,114.11
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3,152,602.87	416,114.11
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,785,571,546.58	1,740,161,531.06
51	Засгийн газрын хувь оролцоо	1,785,571,546.58	1,740,161,531.06
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	675,655,846.74	675,655,846.74
51101	Өмч: - төрийн	675,655,846.74	675,655,846.74
512	Хуримтлагдсан үр дүн	177,859,662.33	132,449,646.81
51210	Өмнөх үеийн үр дүн	177,859,662.33	177,859,662.33

51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-45,410,015.52
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	932,056,037.51	932,056,037.51
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,788,724,149.45	1,740,577,645.17

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,464,053,836.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,666,236.10
120	Нийтлэг татварын бус орлого	7,666,236.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,666,236.10
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,385,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,681,036.10
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,456,387,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,158,975,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,158,975,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	297,412,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	297,412,200.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,509,463,851.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,509,463,851.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,422,958,947.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	836,945,174.55
210101	Үндсэн цалин	836,945,174.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,142,981.82
210201	Тэтгэврийн даатгал	105,142,981.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	254,512,330.00
210301	Гэрэл, цахилгаан	8,556,230.00
210302	Түлш, халаалт	245,956,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	758,000.00
210402	Тээвэр, шатахуун	758,000.00
2105	Нормативт зардал	32,441,520.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,619,870.00
210502	Хоол, хүнс	29,821,650.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,549,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	911,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,638,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	190,609,940.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,796,350.08
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,722,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	133,090,690.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	86,504,904.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	83,520,250.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	83,520,250.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,984,654.27
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,984,654.27

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-45,410,015.52</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-45,410,015.52</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,459,372,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,985,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,985,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,985,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,385,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,456,387,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,158,975,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,158,975,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	297,412,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	297,412,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,431,552,342.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,431,552,342.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,346,578,038.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	849,828,761.72
210101	Үндсэн цалин	606,125,941.41
210102	Нэмэгдэл	226,342,978.31
210104	Урамшуулал	17,359,842.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,838,046.59
210201	Тэтгэврийн даатгал	76,853,332.93
210202	Тэтгэмжийн даатгал	8,771,439.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,017,191.54
210204	Ажилгүйдлийн даатгал	1,752,581.66
210205	Эрүүл мэндийн даатгал	17,443,501.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	255,379,330.00
210301	Гэрэл, цахилгаан	8,556,230.00
210302	Түлш, халаалт	245,956,100.00
210303	Цэвэр, бохир ус	867,000.00
2105	Нормативт зардал	40,276,750.00
210502	Хоол, хүнс	40,276,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	760,500.00
210604	Урсгал засвар	760,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,931,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,931,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79,562,850.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	66,111,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,451,750.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,974,304.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	81,989,650.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	81,989,650.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,984,654.27
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,984,654.27
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	27,820,457.42

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	27,820,457.42
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	27,820,457.42

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	675,655,846.74	932,056,037.51	177,859,662.33	1,785,571,546.58
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	675,655,846.74	932,056,037.51	177,859,662.33	1,785,571,546.58
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	675,655,846.74	932,056,037.51	177,859,662.33	1,785,571,546.58
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-45,410,015.52	-45,410,015.52
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	675,655,846.74	932,056,037.51	132,449,646.81	1,740,161,531.06

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,459,597,600.00	1,431,552,342.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,459,597,600.00	1,431,552,342.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,377,607,600.00	1,055,135,146.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	880,178,400.00	851,719,909.31
210101	Үндсэн цалин	673,504,200.00	613,043,912.92
210102	Нэмэгдэл	199,380,300.00	221,316,154.39
210104	Урамшуулал	7,293,900.00	17,359,842.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,022,200.00	107,722,744.73
210201	Тэтгэврийн даатгал	74,815,200.00	74,054,927.72
210202	Тэтгэмжийн даатгал	8,728,500.00	8,442,215.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,114,900.00	6,753,812.26
210204	Ажилгүйдлийн даатгал	1,760,200.00	1,686,736.77
210205	Эрүүл мэндийн даатгал	17,603,400.00	16,785,052.70

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	255,380,200.00	255,379,330.00
210301	Гэрэл, цахилгаан	8,524,100.00	8,556,230.00
210302	Түлш, халаалт	245,956,100.00	245,956,100.00
210303	Цэвэр, бохир ус	900,000.00	867,000.00
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг		2,984,654.27
2105	Нормативт зардал	40,277,200.00	40,276,750.00
210502	Хоол, хүнс	40,277,200.00	40,276,750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	769,200.00	00.00
210604	Урсгал засвар	769,200.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,932,500.00	8,931,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,932,500.00	8,931,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	81823100.00	79562850.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	68,424,300.00	66,111,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,623,600.00	13,451,750.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	81990000.00	81989650.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	81,990,000.00	81,989,650.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	81,990,000.00	81,989,650.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,459,597,600.00	1,459,597,600.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,159,200,400.00	1,159,200,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,159,200,400.00	1,159,200,400.00
132001	Орон нутгийн төсвөөс санхүүжих	297,412,200.00	297,412,200.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,985,000.00	2,985,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,385,000.00	2,385,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	600,000.00	600,000.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	27,820,457.42
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	58.00	58.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	33.00	33.00
620003	Үйлчлэх ажилтан	24.00	24.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ховд аймгийн Цэцэг сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2022 оны хичээлийн жилийг “Эцэг эхийн хамтын ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулан багш бүр ээлжит хичээлийн бэлтгэлийг чанаржуулж, суралцагчийн хөгжил, төлөвшилд ахиц гаргана.” гэсэн зорилго дэвшүүлэн ажиллаж байна. Энэхүү зорилгынхоо хүрээнд “Багшийн хөгжлийг дэмжих”, “Хүүхдийн хөгжил төлөвшлийг дэмжих”, “Хамтын оролцоог нэмэгдүүлэх гэсэн тэргүүлэх зорилт тавин ажиллажээ.

Ховд аймгийн Цэцэг сумын Ерөнхий боловсролын сургууль нь 4 заах аргын нэгдэлд сургалт бусад үйл ажиллагаа явуулдаг ба байгалийн ухааны заах аргын нэгдэлд-9, нийгмийн ухааны заах аргын нэгдэлд -13, бага ангийн заах аргын нэгдэлд-11, захиргаа аж ахуйн заах аргын нэгдэлд-25, нийт 58 багш ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус сургууль нь бага ангийн-11, дунд, ахлах ангийн-22 багштай. тэргүүлэх 20, заах аргач 6, зэрэггүй 7 нийт багш нарын 78.8 % нь мэргэжлийн зэрэгтэй, 17 багш бакалавр, 13 багш магистр зэрэгтэй байна.

2022 онд хийсэн багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр 3 түвшний багш-1, бусад багш нар V, VI түвшинд шалгагдсан ба нийт оноогоор 72.6 % авч аймгийн дунджаас 1.7 %, улсын дунджаас 3.9 % буурсан амжилтыг үзүүллээ.

Ховд аймгийн Цэцэг сумын Ерөнхий боловсролын сургуульд 2022-2023 оны хичээлийн жилд 1 дүгээр ангид 78 сурагч элсэж, 24 бүлэгт 681 сурагч суралцаж, анги дүүргэлтийн дундаж 32.5 ба бага анги буюу 1-5 дугаар ангийн 11 бүлэгт 358, дунд анги буюу 6-9 дүгээр ангийн 8 бүлэгт 211, ахлах анги буюу 10-12 дугаар ангийн 5 бүлэгт 112 сурагч суралцаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Боловсролын тухай, Бага дунд боловсролын тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд 2022 онд нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. 2022 онд Боловсролын тухай хуульд 3 удаа, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд 2 удаагийн өөрчлөлт оржээ.

Боловсролын байгууллагын багш ажилтанд үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдэл олгох журмуудад өөрчлөлт орсон байна. 2022 онд боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах, багшийн хөгжлийг дэмжих, цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх, хуваарилах, санхүүжүүлэх, багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах журмыг шинээр баталжээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна.

2022 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 02 дугаар 22-ны өдрийн 64 дүгээр тогтоолын дагуу Цэцэг сумын сургуулийн захирлын 2022 оны 09 дүгээр сарын 19-ны А/17 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогыг зохион байгуулж хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдалд хяналт тавих ажлуудыг зохион байгуулсан байна.

Монгол Улсын Засгийн газраас орон даяар зохион байгуулж байгаа Тэр бум мод үндэсний хөдөлгөөний аяны хүрээнд 9-12 ангийн сурагчид сургуулийн хашаан доторх талбайд 100 ширхэг улиас модны хөрсийг боловсруулан суулгацыг суулгав.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэцэг сумын Ерөнхий боловсролын сургууль нь нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ховд аймгийн Цэцэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй, 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 48.1 сая төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая. төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө		27.8	27.8
Авлага	12.2	23.8	11.6
Бараа материал	77.8	73.9	(3.9)
Үндсэн хөрөнгө	1,698.7	1,615.0	(83.7)
Нийт хөрөнгө	1,788.7	1,740.6	(48.1)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,785.5	1,740.1	(45.4)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,788.7	1,740.6	(48.1)

Дээрх хүснэгтээс харахад Цэцэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 48.1 сая төгрөгөөр буурсны материаллаг нөлөө нь элэгдлийн зардал данстай холбоотой байна.

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25 өдрийн 18 дугаартай албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 27.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- ✓ Авлагын данс 23.5 сая төгрөгөөр өссөн нь ажиллагсадтай холбогдсон авлага, нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлттэй холбоотой байна.
- ✓ Бараа материал данс 3.9 сая төгрөгөөр буурахад бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зарцуулалт нөлөөлөл үзүүлсэн байна.

- ✓ Үндсэн хөрөнгө данс 83.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардалтай холбоотой.
- ✓ Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ данс 45.4 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үр дүнтэй холбоотой.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус газрын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1007.4, орон нутгийн төсвөөс 297.4 сая төгрөг нийт 1304.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 154.5 сая төгрөгөөр өсгөж, 1161.9 сая төгрөгөөр баталсан нь цалингийн сан хүрэлцэхгүй байсантай холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвөөс 1,158.9 сая, орон нутгийн төсвөөс 297.4 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2.9 сая төгрөг нийт 1,459.4 сая төгрөг гүйцэтгэлээр санхүүжиж 1,431.1 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж гүйцэтгэлээр санхүүжиж байгаатай холбоотой 27.8 сая төгрөгийн дансны үлдэгдэлтэй байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1161.9 сая төгрөгийн санхүүжилт олгогдож, төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1134.1 сая төгрөг буюу 97.6 хувьтай зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган,төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71802/80226-тогтмол зардал	3,573.0	3,573.0	-	100%
2	71802/80312-сургалт семинар	1,786.5	1,786.5	-	100%
3	70802/81801 -үдийн цай	81,990.0	81,989.6	0.4	99.9%
4	70802/81605-Эрүүл мэнд	4,109.0	4,109.0	-	100%
5	71802/81816-Нөхөн хангалт	41,960.0	41,960.0	-	100%
6	71802/81823-Боловсролын байгууллагын багш	8,039.3	8,039.3	-	100%
7	71802/81834-Боловсролын стандарт	876,930.5	849,808.1	27,122.4	95%
8	71802/81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	83,839.8	83,823.0	16.8	99.9%
9	71802/81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	600.0	600.0	-	100%
10	71802/81848 сурах бичгийн түрээс	2,160.2	2,160.2	-	100%
11	71802/80111-тогтмол зардал	255,379.3	255,379.3	-	100%
12	71802/81806-Дотуур байр	56,747.3	56077.1	680.8	98.8%
13	71802/80112-Нийтлэг үйлчилгээ	42032.9	42032.9		100%

ДҮН	1,459,372.8	1,431,552.4	27,820.4	97.6%
------------	--------------------	--------------------	-----------------	--------------

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Цэцэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Эл би альфа экспэйншин аудит ХХК-ны аудитор Б.Бадамцэцэг, Ховд дахь ТАГ-ын ахлах аудитор Д.Нарантуул, гэрээт аудитор М.Энхжаргал нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар хэрэгжүүлсэн.

2022 оны 03 дугаар сарын 17-ноос 03 дугаар сарын 22-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 41 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,509.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 29.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 23.3 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус газар нь холбогдох заалтуудыг мөрдөн ажиллаагүй байна.

6 дугаар зүйлд заасан шатахууны зардалд тайлант онд 3.9 сая төгрөгийг зарцуулахдаа дотоод хяналт хэрэгжүүлээгүй, шатахууны тооцоо бодоогүй зарцуулсан байна.

10 дугаар зүйлд заасан цалин хөлс, нэмэгдлийн зардалд Үдийн хоолны тогооч нарт 7.9 сая төгрөгийн цалинг үдийн цайны зардлаас санхүүжүүлж гэрээ байгуулаагүй олгосон,

төсөв захирагчийн тушаал шийдвэргүйгээр нийгмийн даатгалын шимтгэл төлж зардал гаргасан.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 125 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 24 байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Хязгаарлалттай” санал дүгнэлт авч 6.2 сая төгрөгийн төлбөрийн акт, 1 заалт бүхий албан шаардлага хүргүүлснээс тогтоосон төлбөрийн актыг хэрэгжүүлж, 1 заалт бүхий албан шаардлагыг хэрэгжүүлж, Аудитын шийдвэрийн нийт биелэлт 52.2 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	/мянган төгрөг/				
	Илрүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	6,253.3	2	3,028.4	48.4
Албан шаардлага	1	1,500.0	1	1,125	75.0
Зөвлөмж	3	100,500.0	1	98,987.0	33.3
Нийт дүн	7	108,253.3	3	103,140.4	52.2

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цэцэг сумын ЕБС-ийн 2022 оны санхүүгийн тайланд тусгасан тоо мэдээлэл нь үнэн зөв илэрхийлэгдсэнийг нотлох боломжгүй нь анхаарал татахуйц дараах асуудлыг дараагийн аудитаар эрсдэлийн аудит болгон авч үзэх шаардлагатай байна. Тухайлбал:

- Авлага барагдуулах, малын тооллого хийж, нас дэвшил, орлого бүртгэх, шатахууны тооцоо бодох зарцуулалтыг анхаарч үзэх

- Эд хариуцагч Б.Очиржавын ХААН банк дахь 5859007990 тоот данс руу 2022 онд нийт 33.2 сая төгрөгийг, мөн жолооч Баяраагийн 111400046987 тоот харилцах дансанд 19.6 сая төгрөгийг бараа, хүнс материалын үнэ, гэж шилжүүлсэн боловч и баримтыг өөрөөсөө хэвлэсэн, хувь хүний харилцах данс руу шилжүүлсэн боловч баримтын бүрдэл хангалтгүй, төрийн сангийн тамгатай дотоод хяналтгүй зарцуулсан, шаардлага хангахгүй баримттай байгаа тул нотлох боломжгүй, тул дараагийн аудитаар нарийвчлан үзэх зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 7.1 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 7.1 сая төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- ✓ **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Боловсрол шинжлэх ухааны газраас хуваарилсан сурах бичиг, түрээсийн номын орлого үндсэн хөрөнгөд бүртгэж аваагүй байсныг залруулж бүртгүүлсэн Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-т "Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана." Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5-т "бүх орлого"; тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.
- ✓ Аудитаар 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайланд өмнөх аудитаар бичигдсэн төлбөрийн актыг найдваргүй авлагын зардалд бүртгэсэн алдааг залруулсан болно.

Аудитаар нийт 35.9 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 12.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, зөрчлийг арилган ажиллах 23.1 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

- Малын тооллого хийж орлого бүртгээгүй, малчинтай гэрээ байгуулж, дүгнээгүй Тайлант онд самнасан ноолуурын зарцуулалт тодорхойгүй төсөв захирагч бэлнээр мөнгө авч зарцуулсантай холбоотой 2.8 сая төгрөг
- Тайлант онд 11 ажилтанд цалингийн урьдчилгаа олгож буцаан суутгаж аваагүй, 1-р сард улирлын амралттай байхад үдийн хоолны 2 тогоочид цалин хөлс олгосон нийт 10.1 сая төгрөг суутган тооцоо хийгээгүй

5.2. Сахилгын шийтгэл ноогдуулах албан шаардлага

- ✓ Төсвийн тухай хуулийн 8.9.1 д зааснаар төсвийн шууд захирагч жилийн санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлэх гэсэн заалтыг зөрчсөн,
- ✓ Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчил илэрлээ.
- ✓ Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

биелүүлээгүй, нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, Шилэн дансны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ”, гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

5.3 Зөвлөмж

5.3.1 Шатахууны зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шатахууны зардалд хяналт хэрэгжүүлээгүйгээс жолоочийн замын хуудасгүй, тооцоо бодоогүй нийт 3.9 сая төгрөгийн шатахуун зарцуулсан зөрчил илэрлээ.

Өгсөн зөвлөмж: Байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтдаа бензиний зөвшөөрөл олгох бичгийг тусган албажуулж нягтлан бодогч, нярав нарын хяналтаар олгож хэвших, шатахууны зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах

5.3.2 Авлага данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нийгмийн даатгалын НД-7Б маягтаар 11.2 сая төгрөгийн авлагатай тайлагнаж материаллаг хэмжээний авлага үүсгэсэн нь нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах 6-р зүйлийн 6.4.8-д төсвийг зохистой удирдаж авлага төлбөр үүсгэхгүй байх гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох 20-р зүйлийн 20.2.5 заалтыг мөрдөн ажиллах

5.3.3 Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сурагчдын үдийн хоол хөтөлбөрийн нийлүүлэлтийг сургууль дотроо бэлтгэж тогооч авч ажиллуулсан боловч гэрээ байгуулаагүй НДШ-г байгууллагаас төлсөн 7.9 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Өгсөн зөвлөмж: Холбогдох журам, тушаалд заасан зардлыг санхүүжүүлэх, тогооч нартай гэрээ байгуулж ажиллах

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл /сая.төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
БШУ Газраас өгсөн сурах бичиг, түрээсийн номын орлого аваагүй	1	4.7	1	4.7			1	4.6
Санхүүгийн тайланд бүртгэгдсэн авлагыг залруулга бичиж найдваргүй авлагын зардалд бичсэн	1	2.25	1	2.25			1	2.2
Шилэн дансанд мэдээлэл байршуулаагүй	1		1					
Санхүүгийн үр дүнгийн тайланд орлого дутуу бүртгэсэн	1	0.22	1	0.22			1	0.22

Дүн	3	7.17					3	7.17

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шатахууны зарцуулалтад тавих хяналтгүй,	1	3.9					1	3.9
НДШ-ийн авлагатай, санхүүгийн тайланд тусгасан	1	11.2					1	11.2
Сурагчдын үдийн хоол хөтөлбөрийн нийлүүлэлтийг сургууль дотроо бэлтгэдэг. Тогооч авч ажиллуулсан боловч гэрээ байгуулаагүй НДШ байгууллагаас төлсөн.	1	7.9					1	7.9
Тайлант онд 11 ажилтанд цалингийн урьдчилгаа олгож буцаан суутгаж аваагүй, 1-р сард сурагчдын улирлын амралттай байхад үдийн хоолны 2 тогоочид цалин хөлс олгосон	1	10.1	1	10.1				
Хариуцлага тооцох	1				1			
Мал амьтдыг тоолоогүй, орлого бүртгээгүй ,гэрээ байгуулаагүй байна	1	2.8	1	2.8				
Дүн	9	35.9	2	12.9	1		3	23.0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОГДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР:

Д.НАРАНТУУЛ

АУДИТОР

Н.ДЭМБЭРЭЛДОРЖ



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 50/A2160424

Ховд

ХОА-2022/164/НА-СТА-ТШЗ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цэцэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланд аудит хийхэд малын ноолуурын орлогыг байгууллагын дансанд төвлөрүүлээгүй 2,840.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай Төсвийн тухай хуулийн 25.7-т "Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана.", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх зөрчилтэй холбоотой 2,840.0 /арван сая нэг зуун дөчин/ мянган төгрөгийг Төрийн сангийн бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2023 оны 05 дугаар сарын 15-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 20-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Цэцэг сумын ЕБС-ийн захирал Д.Мөнхтөр, нягтлан бодогч Г.Гантулга нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

АХЛАХ АУДИТОР

Д.НАРАНТУУЛ



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 41/A2160424

Ховд

ХОА-2022/164/НА-СТА-ТШЗ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цэцэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланд аудит хийхэд багш ажилчдад цалингийн урьдчилгаа олгоод буцаан суутгаж аваагүй, 1-р сард сурагчдын улирлын амралттай байхад үдийн хоолны тогоочид цалин хөлс олгосонтой холбоотой нийт 10,140.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;" 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх зөрчилтэй холбоотой 10,140.0 /арван сая нэг зуун дөчин мянган төгрөг/-ийг хавсралтад заасны дагуу төлүүлэн Төрийн сангийн бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2023 оны 06 дугаар сарын 15-ны дотор төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 20-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Цэцэг сумын ЕБС-ийн захирал Д.Мөнхтөр , нягтлан бодогч Г.Гантулга нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР
АХЛАХ АУДИТОР  Д.НАРАНТУУЛ





ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 03/АЭНДЧН

Ховд

ХОА-2022/164/-СТА-ТШЗ
ХАРИУЦЛАГА ТООЦУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цэцэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар байгууллагын нягтлан бодогч нь ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайланг төрийн аудитын байгууллагад хуулийн хугацаанд ирүүлээгүй, өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цэцэг сумын сургуулийн нягтлан бодогч Г.Гантулгад хуульд заасны дагуу хариуцлага тооцон ажиллаж биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 05-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт¹ хариуг албан бичгээр ирүүлэхийг ирүүлэхийг Цэцэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Мөнхтөрд хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

АХЛАХ АУДИТОР

Д.НАРАНТУУЛ

¹ Монгол улс, Ховд аймаг, Цамбагарав баг, ЗДТГ-ын 3 давхар, Утас: 70433061, 70432545